

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
10 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ НИЙГЭМ СУДЛАЛЫН СОНГОХ ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.05

Хугацаа 80 минут

А хувилбар

Хэрлэн сум

Нийт оноо: 100

Сонгох даалгавар 30, оноо 60

Задгай даалгавар 10, оноо 40

Анги:

Сурагчийн нэр:

Сэргээн санах түвшний даалгавар:

- Аль нь нийгмийн тухай өргөн хүрээгээр тодорхойлсон ойлголт аль нь вэ? /2 оноо/
 - Хүмүүс хэрэгцээгээ хангах, зөрчил маргаан, эмх замбараагүй байдалд хүргэхгүйн тулд үүргээ хуваарилан зохион байгуулалтанд орж, хянаж, зохицуулах замаар амьдарч буй хамтын амьдралынх нь хэлбэр юм.
 - Нийгмийн хэсэг, элементүүдийн хооронд бэхжсэн тогтвортой харилцаа холбоог хэлнэ.
 - Хүн амын болон соёлын нөхөн үйлдвэрлэлээрээ өөрийн залгамж, тогтвортой чананрыг хангадаг, нэг нутаг дэвсгэр дээр амьдардаг, өөрийн зохион байгуулалт эмх цэгц бүхий, улс төрийн хувьд бие даасан, өөрсдийгөө тухайн нийгэмд харьяалуулдаг хүмүүсийн тогтвортой нэгдэл
 - Хүмүүсийн үйлдэл, тэдгээрийн хоорондын харилцан үйлдэл, бөөгнөрөл, хүмүүсийн нэгдэл юм.
- "Хүн бол бэлгэдэл бүтээгч амьтан" гэж дараах эрдэмтдээс хэн нь тодорхойлсон бэ? /2 оноо/
 - А. Р.Бенедикт
 - В. Э.Тайлор
 - С. А.Гидденс
 - Д. Э.Кассирер
- "Хүний үндсэн эрх, хувь хүний нэр төрд итгэх итгэлийг дахин батлах..." гэсэн зорилготой НҮБ хэдэн онд байгуулагдсан бэ? /2 оноо/
 - А.1940 он
 - В.1945 он
 - С.1948 он
 - Д.1992 он
- Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийг орлогын нийлбэр дүнгээр тодорхойлох аргыг гэнэ. /2 оноо/
 - А. ДНБ-ийг орлогоор тооцох
 - В. ҮНБ-ийг зардлаар тооцох
 - С. ДНБ-ийг зардлаар тооцох
 - Д. ҮНБ-ийг орлогоор тооцох
- Иргэд улс төрийн шийдвэр гаргах, хууль боловсруулах үүрэг бүхий албан тушаалтаныг сонгож, түүгээр дамжуулан засаглалыг хэрэгжүүлэх хэлбэр юм. Энд ардчиллын аль хэлбэрийн тухай өгүүлсэн байна вэ? /2 оноо/
 - А. Сонгодог ардчилал
 - В. Шууд ардчилал
 - С. Элит ардчилал
 - Д.Төлөөллийн ардчилал
- Ардчилсан нийгэмд бүх иргэдэд адил тэнцүү боломж олгодог зарчим аль нь вэ? /2 оноо/
 - А. Нээлттэй зарчим
 - В. Шууд ёсны зарчим
 - С. Цөөнхийг хүндэтгэх зарчим
 - Д. Зөвшилцлийн зарчим
- Олон улсын харилцаанд улс орныг албан ёсны гэхдээ бүрэн бус хүлээн зөвшөөрснийг гэж нэрлэдэг. /2 оноо/
 - А.Статус кво
 - В.Де-факто
 - С.Автономит
 - Д.Де-юре
- Үндэсний язгуур эрх ашиг сонирхлыг сахин хамгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйлчилсэн бодлого байна." Энэ нь Монгол улсын гадаад бодлогын аль зарчим бэ? /2 оноо/
 - А. Тэнцвэртэй байх
 - В. Идэвхтэй байх
 - С. Үндэсний эрх ашигт нийцсэн байх
 - Д. Олон тулгуурт байх

Ойлгох түвшний даалгавар:

- Та судалгаа явуулахдаа судалгааны таамаглалыг шалгахад шаардлагатай мэдээллийг олж авахад туслах асуултуудыг судалгааны аль хэсэгт тэмдэглэх вэ? /2 оноо/
 - А. Удиртгал хэсэг
 - В. Судлаачийн тэмдэглэх хэсэг
 - С. Ерөнхий мэдээллийн хэсэг
 - Д. Үндсэн мэдээллийн хэсэг
 - Е. Төгсгөл хэсэг
- Монгол үндэстний соёлын нийтлэг шинжийг тоочихдоо хамааралгүй зүйл оруулсан бол түүнийг олно уу. /2 оноо/
 - А.Монгол орон бол эртний соёлт орон
 - В.Монголын соёл Дорно дахины соёлын хүрээнд хамрагдана
 - С. Нүүдлийн болон суурьшмал иргэдийн соёл зэрэгцэн оршдог
 - Д.Монгол орон бол буддын соёлт орон
 - Е. Марзан Шаравын "Монголын нэг өдөр" уран зураг

11. "Magna charta" буюу "Эрх чөлөөний харти" хэмээх баримт бичигт ямар зарчмыг анхлан тунхагласан байдаг вэ? /2 оноо/
 А. Боолуудыг чөлөөлж, бүх хүмүүс ижил эрхтэй гэдгийг тунхагласан зарчим
 В. Шүүхийн шийдвэргүйгээр улсын хуулиас гадуур хүнийг гэм буруутайд тооцож үл болох зарчим
 С. Хүн бүр тэгш боломжоор хангагдах зарчим
 D. Жендерийн тэгш байдлыг хангах зарчим
12. Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улстөрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал болон нийгэмд эзэлж байгаа байр сууриас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй. Хүний эрхийн суурь зарчмын аль нь вэ? /2 оноо/
 А. Хуваагдашгүй байх
 В. Харилцан хамааралтай байх
 С. Ялгаварлан гадуурхал байх
 D. Түгээмэл, салшгүй байх
13. Хүнд авч байгаа цалингийн хэмжээ, ажлын байрны нөхцөл, хөдөлмөр хамгаалал таалагдаагүйгээс ажлаа өөрчлөх, эсвэл амьдрах газар, орчноо солих шаардлага гарч болдог. Тэрээр тохирох ажил эрж олох хүртэл хэсэг хугацаанд ажилгүй байж болно. Энэ нь: /2 оноо/
 А. Байнгын ажилгүйдэл
 В. Мөчлөгийн ажилгүйдэл
 С. Улирлын ажилгүйдэл
 D. Шилжилтийн ажилгүйдэл
14. $M > \frac{PQ}{T}$ томъёоллын үед эдийн засагт аль нөхцөл үүсэх вэ? /2 оноо \
 А. Эдийн засагт мөнгөний илүүдэл бий болж, мөнгө үнэ цэнээ алдаж, улмаар инфляци үүснэ.
 В. Мөнгөний хомсдол бий болж нийт эрэлт буурна.
 С. Мөнгөний тоо үйлдвэрлэсэн бараа үйлчилгээ тэнцэж, эдийн засаг тогтвортой байна.
 D. В ба С нөхцөл үүснэ.
15. Ардчилсан нийгэм нь иргэдийн эрхийг хамгаалах, үйлчлэх анхдагч үүргээ сонгуульт албан тушаалтан, төрийн албан хаагчдын эрх мэдлээ урвуулан, хэтрүүлэн ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх боломжийг олгодог. Энэ нь ардчиллын ямар үнэт зүйлсэд хамаарах ойлголт вэ? /2 оноо/
 А. Эрх мэдлээ хэтрүүлэхэд хяналт тавих
 В. Хуулийн засаглал
 С. Нийтэд тайлагнах, ил тод байх ёс
 D. Тогтмол, чөлөөт шударга сонгууль
16. Фрийдом Хаус байгууллагын судалгаагаар 2016 онд Монгол улс хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн аль ангилалд багтсан бэ? /2 оноо/
 А. Хагас чөлөөтэй улс
 В. Чөлөөт буюу эрх чөлөөт улс
 С. Хагас чөлөөтэй буюу бүрэн бус улс
 D. Чөлөөт улс
 E. Авилгын төсөөллийн индекс багатай улс
17. Төр, засгийн оролцоогүйгээр сайн дурын үндсэн дээр иргэдийн санаачилсан үйл хэрэгт тулгуурласан байгуулагдсан төрөл бүрийн байгууллага болон олон улсын байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагаанд тодорхой үүрэг, чиглэлээр оролцож байгаа олон улсын харилцааны оролцогч аль нь вэ? /2 оноо/
 А. Төрийн бус байгууллага
 В. Улаан Загалмайн Нийгэмлэг
 С. Үндэстэн дамнасан корпораци
 D. Олон улсын байгууллага
18. Бага улсыг олон улсын харилцааны чухал оролцогч гэж үзэх гол үндэслэл юу вэ? /2 оноо/
 А. Ихэнх бага улс цэрэг-зэвсэгт хүчний хувьд сул, эдийн засгийн хувьд хөгжингүй
 В. Ихэнх бага улс эдийн засгийн хувьд хөгжиж буй боловч цэрэг- зэвсэгт хүчин сайтай
 С. Ихэнх бага улс цэрэг- зэвсэгт хүчний хувьд сул ч дэлхийн улсуудын гуравны хоёр нь
 D. Улс орнуудыг их, бага улс гэж ангилдаггүй

Хэрэглэх түвшний даалгавар:

19. дараах жишээг уншаад аль нь олдмол статусынх болохыг олно уу. /2 оноо/
 А. Би айлын дунд хүү
 В. Миний ээж Боржигин овогтой
 С. Иргэн Г. Сумъяа Завхан аймгийн уугуул
 D. Сурагч Б. Эрхсаран FM радиогийн хөтлөгчөөр ажилладаг.
20. Адилтгах замаар хариуг бичнэ үү. /2 оноо/
 Төрөөс албадлага ашигладаг гажуудлын нэгдэх төрөл –Гэмт хэрэг
 Төрөөс албадлага ашигладаг гажуудлын хоёр дахь төрөл-
21. Үнэлэмжүүдийн өгөгдлийг зөв харгалзуулна уу. /2 оноо/

1	Ёс суртахууны үнэлэмж	a	сайхан, муухай
2	Шашны үнэлэмж	b	буян, нүгэл
3	Гоо сайхны үнэлэмж	c	сайн, муу
4	Шинжлэх ухааны үнэлэмж	d	үнэн, худал

A. 1d 2c 3a 4b B. 1a 2d 3b 4c C. 1c 2b 3a 4d D. 1ccf 2a 3d 4b E. 1b 2a 3c 4d
 22. "Сургуулийн хонх бол хичээл элэхлсэн дууссаныг илтгэх тэмдэг" нь соёлын аль чиг үүрэгт тохирохыг олно уу. /2 оноо/

A. Бэлгэдлийн чиг үүрэг

B. Үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг

C. Нэгтгэн зохицуулах чиг үүрэг

D. Үйл ажиллагааны чиг үүрэг

23. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу. /2 оноо/

1	Тэгш байдлыг хангах	a	Хүний эрх нь амьдралын бүхий л хүрээг хамрах бөгөөд өөрөөр хэлбэл нэг эрх нь зөрчигдөхөд бусад эрхүүдэд нөлөөлнө.
2	Ялгаварлан гадуурхахгүй байх	b	Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл, хуваагдашгүй байдаг.
3	Хүн үнэ цэн, нэр төртэй байх	c	Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнтэй байж, адил хүндэтгэлийг эдэлнэ.
4	Хуваагдашгүй байх	d	Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, нийгмийн гарал, өмч хөрөнгө төрсөн байдал зэргээс үл хамааран хэнийг ч ялгаварлаж болохгүй
5	Харилцан хамааралтай байх	e	Бүх хүмүүс хүн болж төрснийхөө хувьд ижил үнэлэгдэж, адил хүндлэл хүлээнэ гэдгийг баталгаажуулдаг.

A. 1c 2b 3d 4a 5e

B. 1e 2b 3d 4c 5a

C. 1a 2b 3c 4b 5d

D. 1a 2c 3b 4d 4e

24. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу. /2 оноо/

1	Монгол улсын Үндсэн хууль	a	Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	b	Эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн баялгаас тэнцүү хүртэх боломж, нөхцлийг хангах
3	Эрүүгийн хууль	c	Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна.
4	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	d	Эрүүгийн харицлага нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна.
5	Зөрчлийн тухай хууль	e	Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх нь иргэний үндсэн үүрэг

A. 1c 2b 3d 4a 5e

B. 1e 2b 3d 4c 5a

C. 1a 2b 3c 4b 5d

D. 1a 2c 3b 4d 4e

E. 1c 2a 3d 4e 5b

25. Дараах жишээнүүд тэтгэвэр, тэтгэмжийн аль төрөлд хамаарахыг цэгийн оронд нөхөж бичнэ үү. /2 оноо/

1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж

2. Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж

3. Ажилгүйдлийн тэтгэмж

4. Оршуулгын тэтгэмж

a. Иргэн Шинэтулга саяхан ажлаасаа халагдсан бөгөөд ажилгүй болсон тухайгаа дүүргийн хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлсэн.

b. Барилгын компанид ажилладаг иргэн Цолмон ажил үүргээ гүйцэтгэх үедээ хөлөө хугалсан.

c. Иргэн Бурмаа жирэмсэн тул ажлаасаа түр чөлөөлөгдсөн

d. Иргэн Болд энэ сард өндөр настны тэтгэвэрт гарсан боловч удалгүй нас барсан.

A. 1d 2c 3b 4a

B. 1a 2b 3c 4d

C. 1b 2c 3a 4d

D. 1c 2a 3d 4b

26. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. /2 оноо/

1. Өрх гэрийн хэрэглээний зардал хангасан

a. ЕБС-ийн багш нарыг зөөврийн компьютерээр

2. Аж ахуйн нэгжийн зардал

b. Сувдаа гэртээ талх, мах гурил худалдаж авсан

3. Төрийн зардал

c. Женко Турк компани Чингисийн хөшөө босгосон

4. Гадаад хэрэглэгчийн зардал

d. Говь ХК ноолууран бүтээгдэхүүнээ Хятад улс руу гаргасан

A. 1d 2c 3b 4a

B. 1a 2b 3c 4d

C. 1b 2c 3a 4d

D. 1c 2a 3d 4b

27. Ард иргэд засгийн газарт санал хүсэлтээ илэрхийлэх боломжид аль нь хамаарахгүй вэ? /2 оноо/
- A. Нэг цонхны үйлчилгээнд хандаж саналаа өгөх
 - B. Орон нутагт төр захиргааны байгууллагадаа хандаж саналаа өгөх
 - C. ТҮЦ машинаар санал өгөх
 - D. Олон нийтийн сүлжээгээр өөрийн санал бодлоо илэрхийлж пост бичих
28. 1992 оны шинэ Үндсэн хуулинд Монгол Улсын Их Хурлын тухай заасан байдаг. Доорх өгөгдөлүүдээс аль нь алдаатай вэ? /2 оноо/
- A. Монгол Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллага мөн.
 - B. Монгол Улсын Их Хурал нь хууль тогтоох эрх мэдлийг хадгална.
 - C. Монгол Улсын Их Хурал нь өршөөл үзүүлнэ.
 - D. Монгол Улсын Их Хурал нь нэг танхимтай бөгөөд чуулган хэлбэрээр хуралдана.
 - E. Монгол Улсын Их Хурал нь засгийн газар төрийн бүх ажлаа хариуцна
29. Дараах бодомжуудаас аль нь алдаатай байна вэ? (Монгол улс, ОХУ-ын хамтарсан гол баримт бичгүүд) /2 оноо/
- A. 2009 онд Стратегийн түншлэл хөгжүүлэх тунхаглал баталсан
 - B. 2006 онд Москвагийн тунхаглал баталсан
 - C. 2000 онд Улаанбаатарын тунхаглал баталса
 - D. 1993 онд Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулсан
 - E. 1993 онд Бага банди, 2000 онд В.Путин нар төрийн айлчлал хийсэн
30. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүнүүдийн уулзалт, хуралдаан Бүгд Найрамдах Тажикистан Улсын нийслэл Душанбе хотод 2021 оны 9 сарын 16-18-нд боллоо. Хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн бие төлөөлөгчөөр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Душанбе хотноо очиж биечлэн оролцов. /Эх сурвалж: <https://www.montsame.mn/>
- Эх сурвалжид үндэслэн Монгол улсын улс төрийн гадаад харилцааны бодлогын зорилгод хамааралгүй хэсгийг сонгоно уу. /2 оноо/
- A. Дипломат болон консулын харилцааг хөгжүүлэх
 - B. Нөлөө бүхий улсуудтай харилцааныхаа түвшинг дээшлүүлэх
 - C. Олон улсын байгууллагын үйл ажиллагаанд үл оролцох
 - D. Дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах
 - E. асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах

Задлан шинжлэх түвшний даалгавар:

31. Байр суурийг төрөлхийн ба олдмол гэж ангилдаг. Олдмол байр суурийн жишээг нэрлээрэй. /4 оноо/

1. 2.
3. 4.

32. Дараах мэдээлэлд тулгуурлан дараах асуултад хариулаарай. /4 оноо/

Мэдээлэл 1. Сэлэнгэ аймгийн Мандал сумын уяачид гол төлөв хэд хэдэн айлууд нийлж, нэг гал болж морио сойх нь элбэг байна. Наадам болохоос ойролцоогоор нэг сар гаруйн өмнөөс уяж, бага багаар уяанд нь дасгаж, хоол тэжээлийг нь багасгаж байгаад богино зайд үсэргэж эхэлнэ. Ингэхдээ гол төлөв олон жил уясан, их насны морьдоо эхэлж үсэргэдэг байна. Хурдан морь уяхдаа билгийн тооллын нохой өдөр уяж, мориныхоо уяан дээр арц, хүж уугуулан, ариулж, хийморь лундаа сэргээх, аюул барцадаас хамгаалах зорилго бүхий ном хуруулж, тусгай зан үйл хийнэ. Морь сойж байх хугацаандаа тарга хүч ихтэй бол богино зайд ширүүн явдлаар давхиулж, хөлсийг нь авдаг. Ингэж хөлс авах хоёр төрөл байх агаад нэг нь битүү нэмнээгээр хучиж, нөгөө нь задгай буюу нэмнээгүйгээр давхиулж хөлс авдаг. Авах хөлсний хэмжээ их биш бол задгайгаар хөлс авдаг байна. Өөр нэг арганы усанд шумбуулж, дотроос нь хүйтэн жингээр биеийг нь хөнгөрүүлдэг байна. "...Сар гаруй хугацаанд азарга, соёолон бол гайгүй болчихно. Сойж байгаа морь ханиад хүрвэл манайх бол тогооны угаалтуур хийдэг боролзгоныг усанд хийж буцалгаад, усыг нь шүүж аваад уулгадаг юм. Үндсэндээ хандалж уулгаж байна гэсэн үг. Аль болох өтгөн байвал сайн байдаг юм" гэж уяачид ярьж байна.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг дахь Гацууртын орд, түүний орчны бүсэд хийсэн угсаатны зүйн хээрийн судалгааны ажлын тайлангаас. УБ.2015. 39 тал

Хурдан морины соёл нь соёлын аль бүрдүүлэгч элементүүдтэй холбоо хамааралтай вэ? /1 оноо/

.....

Яагаад? /3 оноо/

.....

33. Дараах мэдээллийг уншаад асуултад хариулаарай. / 4 оноо/

Мэдээлэл 2. Боловсрол эзэмших эрхийн төлөө тэмцэгч Пакистан охин Малала Юсуфзай “Би өөрийнхөө тухай түүхийг хүмүүст ярьж өгөхийг хүсч байна. Бас би боловсрол эзэмшиж чадахгүй байгаа 61 сая хүүхдийн түүхийг ч бас яримаар байна. Би бүх охид, хөвгүүдийн суралцах эрхийг хамгаалахыг хүсч байна. Учир нь энэ бол тэдний үндсэн эрх шүү дээ. Нэг хүүхэд, нэг багш, нэг үзэг, нэг ном дэлхийг өөрчилж чадна” хэмээн хэлсэн байна.

Малала охины сурч боловсрох эрхийн талаарх үзэл бодлыг тайлбарлан бичнэ үү.

Малала охины түүхээс Пакистан улсын иргэдийн эрхийн асуудал ямар байгааг төсөөлөн бичнэ үү.

34. Цэгийн оронд тохирох үндсэн хуулийн суурь зарчмыг нөхөж бичнэ үү. Нөхөх үгс: /Ардчилсан ёс, эрх чөлөө,шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх,үндэсний эв нэгдлийг хангах/ /4 оноо/

1. Нийгэмд эзлэх байр суурь, албан тушаал, анги, давхарга, шашин шүтлэг, үзэл бодол, нас хүйс, бэлгийн чиг баримжаанаас үл хамаарч, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх

2. Үнэн зөв байх, онол, арга зүй, практикийн бодит үнэнд шүтсэн, зөвийг дээдэлж энэрэн хүндэтгэж, хөхиүлэн дэмждэг, бурууг ялган салгаж жигшин зэвүүцэж чаддаг байх,

3. өөрийн улсад амьдарч аж төрж байгаа үндэстэн, ястан, овог, аймгийн эв зөийг хангах,

4. Үндсэн хуулийг хүндэтгэн биелүүлэх, төрийн бусад хууль тогтоомжийг

35. Нэрлэсэн ДНБ 2016 онд 25700.0 сая. төгрөгт хүрсэн бөгөөд энэ хугацаанд бараа, үйлчилгээний үнэ 14 хувиар өссөн бол тухайн оны инфляцийн түвшинг тооцоолоорой. /4 оноо/

Хэрэглээний үнийн индекс: $БДНБ = \frac{НДНБ}{I}$

36. . Нэрлэсэн ДНБ 2016 онд 25700.0 сая. төгрөгт хүрсэн бөгөөд энэ хугацаанд бараа, үйлчилгээний үнэ 14 хувиар өссөн бодит ДНБ-ийг тодорхойлно уу. /4 оноо/

37. МУ-ын Үндсэн хуульд зааснаар иргэний үндсэн үүргийг ялган бичээрэй. /4 оноо/

Монгол улсын иргэний үүрэг	Үндсэн үүрэг
1. Хуулийг дээдлэн хүндэтгэх,сахин биелүүлэх	
2. Хөдөлмөрлөх	
3. Байгаль орчноо хамгаалах	
4. Албан татвар төлөх
5. Эрүүл мэндээ хамгаалах
6. Эх орноо хамгаалах,цэргийн алба хаах
7. Хүний нэр төр,алдар хүнд,эрх,хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх
8. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх	

38. Төрийн байгууллага ямар эрх зүйн актын төрлийг нөхөж бичээрэй.

№	Төрийн байгууллага	Эрх зүйн актын төрөл
1	МУ-ын Үндсэн хуулийн цэц	
2	МУ-ын Их Хурал	
3	Монгол Улсын Ерөнхий сайд	
4	МУ-ын засаг дарга	

Дараах хүснэгтийг ашиглаад 39, 40 дүгээр даалгаврын асуултад хариулаарай.

Үзүүлэлтүүд	Их гүрний төлөөлөл ОХУ-ын талаарх мэдээлэл	Дунд улсын төлөөлөл БНСУ-ын талаарх мэдээлэл	Бага улсын төлөөлөл Монгол улсын талаарх мэдээлэл
Газар нутгийн хэмжээ (тал, км/мян)	17 сая ам дөрвөлжин км	100 мян ам дөрвөлжин км	1.5 сая ам дөрвөлжин км
Хүн амын тоо (сая)	144	51	3
ДНБ-ий нийт хэмжээ (тэрбум \$)	1.2	1.4	11 мян
Зэвсэгт хүчний зардал (ДНБ-д эзлэх хувь)	5.4	2.6	0.9
Худалдааны нийт эргэлт (ДНБ-д эзлэх хувь)	37	64	74

39. Их гүрэн, дунд, бага улсын гол шалгуур нь юу вэ? /4 оноо/

.....

.....

.....

.....

.....

40. Хүн амын тоо тухайн улсын эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөөлж байна вэ? /4 оноо/

.....

.....

.....

.....

.....

.....

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
10 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ НИЙГЭМ СУДЛАЛЫН СОНГОХ ШИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.05

Хугацаа 80 минут

В хувилбар

Хэрлэн сум

Нийт оноо: 100

Сонгох даалгавар 30, оноо 60

Задгай даалгавар 10, оноо 40

Анги:

Сурагчийн нэр:

Сэргээн санах түвшний даалгавар:

- Аль нь нийгмийн тухай явцуу хүрээгээр тодорхойлсон ойлголт аль нь вэ? /2 оноо/
 - Хүмүүс хэрэгцээгээ хангах, зөрчил маргаан, эмх замбараагүй байдалд хүргэхгүйн тулд үүргээ хуваарилан зохион байгуулалтанд орж, хянаж, зохицуулах замаар амьдарч буй хамтын амьдралынх нь хэлбэр юм.
 - Нийгмийн хэсэг, элементүүдийн хооронд бэхжсэн тогтвортой харилцаа холбоог хэлнэ.
 - Хүн амын болон соёлын нөхөн үйлдвэрлэлээрээ өөрийн залгамж, тогтвортой чананрыг хангадаг, нэг нутаг дэвсгэр дээр амьдардаг, өөрийн зохион байгуулалт эмх цэгц бүхий, улс төрийн хувьд бие даасан, өөрсдийгөө тухайн нийгэмд харьяалуулдаг хүмүүсийн тогтвортой нэгдэл.
 - Хүмүүсийн үйлдэл, тэдгээрийн хоорондын харилцан үйлдэл, бөөгнөрөл, хүмүүсийн нэгдэл юм.
- "Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар, дадлуудыг багтаасан цогц бүхэл юм" гэж дараах эрдэмтдээс хэн нь үзсэн бэ? /2 оноо/
 - А. Р.Бенедикт
 - В. Э.Тайлор
 - С. А.Гидденс
 - Д. Э.Кассирер
- НҮБ хэдэн онд "Хүний эрхийн түгээмэл тунхаглал" хэмээх баримт бичгийг батлан гаргасан бэ? /2 оноо/
 - А.1940 он
 - В.1945 он
 - С.1948 он
 - Д.1992 он
- Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын нийлбэр дүнгээр тодорхойлох аргыг гэнэ. /2 оноо/
 - А. ДНБ-ийг орлогоор тооцох
 - В.ҮНБ-ийг зардлаар тооцох
 - С. ДНБ-ийг зардлаар тооцох
 - Д.ҮНБ-ийг орлогоор тооцох
- Олон түмэн өөрөө өөрийгөө удирдах хэлбэр бөгөөд Эртний Грект иргэн бүрийг төрийг удирдах хэрэгт оролцуулдаг ардчилсан төрийн хэлбэр анх үүссэн юм. Энд ардчиллын аль хэлбэрийн тухай өгүүлсэн байна вэ? /2 оноо/
 - А. Сонгодог ардчилал
 - В. Шууд ардчилал
 - С. Элит ардчилал
 - Д.Төлөөллийн ардчилал
- Улс төрийн намууд, нийгмийн бүлгүүдийн хооронд үзэл бодол, байр суурийн ялгааг нэгтгэх арга зам бөгөөд хэн нэгний эрх ашгийг хөсөрдүүлдэггүй давуу талтай ардчиллын зарчим аль нь вэ? /2 оноо/
 - А.Нээлттэй зарчим
 - В.Шууд ёсны зарчим
 - С.Цөөнхийг хүндэтгэх зарчим
 - Д.Зөвшилцлийн зарчим
- Олон улсын харилцаанд хууль ёсны гэх ба тухайн улсыг бүрэн зөвшөөрснийг гэж нэрлэдэг. /2 оноо/
 - А.Статус кво
 - В.Де-факто
 - С.Автономит
 - Д.Де-юре
- "Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллахдаа шат дарааллыг эрхэмлэсэн, Монгол улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэсэн байна" Энэ нь Монгол улсын гадаад бодлогын аль зарчим бэ? /2 оноо/
 - А.Тэнцвэртэй байх
 - В.Идэвхтэй байх
 - С.Үндэсний эрх ашигт нийцсэн байх
 - Д. Олон тулгуурт байх

Ойлгох түвшний даалгавар:

- Нийгмийн бүтцийг макро түвшинд хийсвэрлэн илэрхийлж буй ойлголт бөгөөд нийгмийн тодорхой хэрэгцээг хангахын төлөө хэм хэмжээтэй, дахин давтагддаг үйлдлээрээ холбогдсон нийгмийн байр сууриудын нэгдлийг хэрхэн нэрлэдэг вэ? /2 оноо/
 - А.Нийгмийн үүрэг
 - В.Нийгмийн статус
 - С.Нийгмийн институт
 - Д.Нийгмийн хяналт

10. Монголын соёлын нэгдмэл шинжид аль нь хамаарахгүй вэ? /2 оноо/

- A. Монгол аж төрөх ёс, ардын урлаг, хэл, төрт ёс, аман болон бичгийн соёл, хуримтлуулсан мэдлэг туршлага, ёс заншил
 B. "Би монгол хүн" хэмээн бахархах
 C. Могол, Казак, үндэсний соёлоос бүрддэг
 D. Бүгд хамаарна

11. Нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаанд аль бодомж нь хамаарах вэ? /2 оноо/

- A. Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр тогтоолгоно.
 B. Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар, түүний сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд олгоно.
 C. Даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс 9 сард нь тасралтгүй төлсөн бол тэтгэмж авах эрх үүснэ.
 D. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн бол түүний оршуулгад зориулан тэтгэмж олгоно.

12. Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улстөрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал болон нийгэмд эзэлж байгаа байр сууриас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй. Хүний эрхийн суурь зарчмын аль нь вэ?

/2 оноо/

- A. Хуваагдашгүй байх
 B. Харилцан хамааралтай байх
 C. Ялгаварлан гадуурхал байх
 D. Түгээмэл, салшгүй байх

13. Хүнд авч байгаа цалингийн хэмжээ, ажлын байрны нөхцөл, хөдөлмөр хамгаалал таалагдаагүйгээс ажлаа өөрчлөх, эсвэл амьдрах газар, орчноо солих шаардлага гарч болдог. Мөн эдийн засгийн хямралаас болж үүсэх ажилгүйдэл бол...

/2 оноо \

- A. Шилжилтийн
 B. Улирлын
 C. Бүтцийн
 D. Мөчлөгийн

14. $M < \frac{PQ}{T}$ томъёоллын үед эдийн засагт аль нөхцөл үүсэх вэ? /2 оноо/

- A. Эдийн засагт мөнгөний илүүдэл бий болж, мөнгө үнэ цэнээ алдаж, улмаар инфляци үүснэ.
 B. Мөнгөний хомсдол бий болж нийт эрэлт буурна.
 C. Мөнгөний тоо үйлдвэрлэсэн бараа үйлчилгээ тэнцэж, эдийн засаг тогтвортой байна.
 D. B ба C нөхцөл үүснэ.

15. Иргэдийн зүгээс улс төрчид, төрийн албан хаагчдад хяналт тавих, тэдний үйл ажиллагааг сайжруулах, авилга, хээл хахуульд өртөхөөс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлдэг. Энэ нь ардчиллын ямар зарчимд хамаарах ойлголт вэ? /2 оноо/

- A. Хууль дээдлэх зарчим
 B. Цөөнхийг хүндэтгэх зарчим
 C. Зөвшилцлийн зарчим
 D. Нээлттэй зарчим

16. 1990 оны дараах Монгол төрийн үйл ажиллагаанд аль нь үл хамаарах вэ? /2 оноо/

- A. Хуульд захирагдан амьдрах ба шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй
 B. Хувийн өмчтэй байхыг зөвшөөрч, түүнийхээ үр шимээр амьдрах
 C. Сонгох, сонгогдох ардчилсан эрхээ бодитоор эдлэж хэрэгжүүлэх
 D. Социалист орнуудын пролетарийн интернационализмд үнэнч байх

17. Гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах бодлого (Гадаадад суугаа бүрэн эрхт төлөөлөгч өөрийн орны иргэдийн эрх ашгийг олон улсын гэрээний хүрээнд хамгаалах, шаардлагатай үед туслалцаа үзүүлэх) аль баримт бичигт тусгагдсан байдаг вэ? /2 оноо/

- A. Монгол Улсын Үндсэн хууль
 B. Зөрчлийн тухай хууль
 C. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал
 D. Хамтын ажиллагааны пакт

18. Үндэсний сонирхлыг тусгасан зорилгуудыг тодорхойлох, бусад улс олон улсын байгууллагад нөлөөлөх замаар тэдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрхэн нэрлэдэг вэ? /2 оноо/

- A. Эдийн засгийн олон тулгуурт бүтэц
 B. Улс төрийн дотоод бодлого
 C. Улс төрийн гадаад бодлого
 D. Эдийн засгийн аюулгүй байдал

19. Аль нь төрөлх статусын жишээ вэ?

- A. Иргэн
 B. Миний охин сурагч
 C. Миний аав багш
 D. Б. Батбаяр тэргүүлэх зэргийн багш болжээ.

20. Адилтгах замаар хариуг бичнэ үү. /2 оноо/

Конформист- Аялдах үйлдэл

Девиаци-

21. Үнэлэмжүүдийн өгөгдлийг зөв харгалзуулна уу. /2 оноо/

1	Ёс суртахууны үнэлэмж	a	сайхан, муухай
2	Шашны үнэлэмж	b	буйан, нүгэл
3	Гоо сайхны үнэлэмж	c	сайн, муу
4	Шинжлэх ухааны үнэлэмж	d	үнэн, худал

A. 1d 2c 3a 4b

B. 1a 2d 3b 4c

C. 1c 2b 3a 4d

D. 1ccf 2a 3d 4b

E. 1b 2a 3c 4d

22. Жишээг уншаад соёлын аль чиг үүрэгт тохирохыг олно уу.

"Хүмүүс юуг сайн гэх юуг зохисгүй гэж үзэхийг ялгах байдал"

A. Бэлгэдлийн чиг үүрэг

B. Үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг

C. Нэгтгэн зохицуулах чиг үүрэг

D. Үйл ажиллагааны чиг үүрэг

23. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу. /2 оноо/

1	Монгол улсын Үндсэн хууль	a	Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	b	Эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн баялгаас тэнцүү хүртэх боломж, нөхцлийг хангах
3	Эрүүгийн хууль	c	Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна.
4	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	d	Эрүүгийн харицлага нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна.
5	Зөрчлийн тухай хууль	e	Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх нь иргэний үндсэн үүрэг

A. 1c 2b 3d 4a 5e

B. 1e 2b 3d 4c 5a

C. 1a 2b 3c 4b 5d

D. 1a 2c 3b 4d 4e

24. Дараах жишээнүүд тэтгэвэр, тэтгэмжийн аль төрөлд хамаарахыг цэгийн оронд нөхөж бичнэ үү. /2 оноо/

5. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж

6. Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж

7. Ажилгүйдлийн тэтгэмж

8. Оршуулгын тэтгэмж

A.....Иргэн Шинэтулга саяхан ажлаасаа халагдсан бөгөөд ажилгүй болсон тухайгаа дүүргийн хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлсэн.

B.....Барилгын компанид ажилладаг иргэн Цолмон ажил үүргээ гүйцэтгэх үедээ хөлөө хугалсан.

C.....Иргэн Бурмаа жирэмсэн тул ажлаасаа түр чөлөөлөгдсөн

D.....Иргэн Болд энэ сард өндөр настны тэтгэвэрт гарсан боловч удалгүй нас барсан.

A. 1d 2c 3b 4a

B. 1a 2b 3c 4d

C. 1b 2c 3a 4d

D. 1c 2a 3d 4b

25. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. /2 оноо/

1. Өрх гэрийн хэрэглээний зардал хангасан

a. ЕБС-ийн багш нарыг зөөврийн компьютерээр

2. Аж ахуйн нэгжийн зардал

b. Сувдаа гэртээ талх, мах гурил худалдаж авсан

3. Төрийн зардал

c. Женко Турк компани Чингисийн хөшөө босгосон

4. Гадаад хэрэглэгчийн зардал

d. Говь ХК ноолууран бүтээгдэхүүнээ Хятад улс руу гаргасан

A. 1d 2c 3b 4a

B. 1a 2b 3c 4d

C. 1b 2c 3a 4d

D. 1c 2a 3d 4b

26. Утгаар нь зөв тохируулна уу. /2 оноо/

1. Гипер инфляци

a. Инфляцийн хурд 54.2 %

2. Цогио инфляци

b. Инфляцийн хурд 123.7 %

3. Мөлхөө инфляци

c. Инфляцийн хурд 4.7 %

A. 1b 2c 3a

B. 1b 2a 3c

C. 1a 2b 3c

D. 1c 2a 3b

27. Засгийн газар ард түмний өмнө дараах үүргүүдээс алийг нь хүлээхгүй вэ? /2 оноо/

A. Нийгмийн харилцааны амар амгалан, тайван байдлыг хамгаална

B. Шударга өрсөлдөөнийг дэмжих замаар эдийн засгийн өрсөлдөөнийг бий болгоно

C. Хүрээлэн буй орчныг хамгаална

D. Бүх нийтийг дээд боловсролтой болгох

28. 1992 оны шинэ Үндсэн хуулинд Монгол улсын Засгийн газрын тухай заасан байдаг. Доорх өгөгдөлүүдээс аль нь алдаатай вэ? /2 оноо/

A. Монгол Улсын Засгийн газар нь Ерөнхий сайд, гишүүдээс бүрддэг хамтын удирдлагын байгууллага юм.

B. Ерөнхий сайдыг Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр УИХ-аас томилох ба Засгийн газрын бусад гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр УИХ томилдог

C. Засгийн газрын үйл ажиллагааны эрх зүйн хэлбэр нь түүний тогтоол, захирамж юм.

D. Засгийн газрыг Ерөнхий сайд удирдамж, төрийн хууль биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцах ба гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага

29. Дараах бодомжуудаас аль нь алдаатай байна вэ? (Монгол улс, БНХАУ-ын хамтарсан гол баримт бичгүүд) /2 оноо/

- A. 2014 онд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон
- B. 2013 онд Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр баталсан
- C. 2011 онд Стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон
- D. 1994 онд Монгол улсын ерөнхийлөгч П.Очирбат төрийн айлчлал хийсэн
- E. 1994 онд Монгол улсын ерөнхийлөгч Н. Багабанди төрийн айлчлал хийсэн

30. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүнүүдийн уулзалт, хуралдаан Бүгд Найрамдах Тажикистан Улсын нийслэл Душанбе хотод 2021 оны 9 сарын 16-18-нд боллоо. Хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн бие төлөөлөгчөөр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Душанбе хотноо очиж биечлэн оролцов. /Эх сурвалж: <https://www.montsame.mn/> Эх сурвалжид үндэслэн Монгол улсын улс төрийн гадаад харилцааны бодлогын зорилгод хамааралгүй хэсгийг сонгоно уу.

- A. Дипломат болон консулын харилцааг хөгжүүлэх
- B. Нөлөө бүхий улсуудтай харилцааныхаа түвшинг дээшлүүлэх
- C. Олон улсын байгууллагын үйл ажиллагаанд үл оролцох
- D. Дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах
- E. асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах

Задлан шинжлэх түвшний даалгавар:

31. Байр суурийг төрөлхийн ба олдмол гэж ангилдаг. Төрөлхийн байр суурийн жишээг нэрлээрэй.

- 1.....
- 2.....
- 3.....
- 4.....

32. Дараах мэдээлэлд тулгуурлан дараах асуултад хариулаарай. /4 оноо/

Мэдээлэл 1. Биелгээ нь монголчуудын аж амьдралаас үүсчээ. Биелгээнд ихэвчлэн амьдрал дээр хийж гүйцэтгэдэг зан үйлүүдийг хийдэг. Жишээ нь, цайныхаа дээж, цацлыг уул усандаа өргөх, юм оёх, тариа тээрэмдэх буюу тариа татах, ноос савах, бөх барилдах, нум сум харвах, морины явдал зэргээр биелдэг. Монгол бүжгийн намба төрх, монгол хүний сэтгэл хөдлөлийн онцлог чанарыг угсаатны бүжиг, бий биелгээнээс салгах аргагүй юм. Төв халхын бүжигт монгол хүний эрхэмсэг чанар, ёслол хүндэтгэлийн намба төрх, гунхах, ганхах, туялзах хөдөлгөөн голлодог бол баруун монголын захчин, торгууд, урианхай дөрвөд, хотон, баяд өөлд ястны бүжигт гарын болон цээжин биеийн огцом түргэн хөдөлгөөн, дал мөрний хаялга, сугсралт, солбилт зэрэг нийтлэг намба төрх давамгайлна.

Соёлын аль бүрдүүлэгч элементүүдтэй холбоо хамааралтай вэ? /1 оноо/

Яагаад? /3 оноо/

33. **Эх сурвалж 2.** 1963 онд Вашингтонд болсон иргэдийн эрхийн төлөө жагсаалын үеэр Мартин Лютер Кинг "Надад мөрөөдөл бий" илтгэлдээ: "Миний дөрвөн хүүхэд нэгэн өдөр арьсны өнгөөрөө бус, өөрийн чадвар, чадлаараа үнэлэгдэх тийм улсад амьдраасай гэж би мөрөөддөг" гэж хэлсэн. Мартин Лютер Кингийн хэлсэн үгс хүний эрхийн ямар асуудлыг хөндсөн бэ?

Арьс өнгөөр гадуурхах үзэл нь хүний эрхийн ямар зарчмыг зөрчиж байна вэ?

34. Цэгийн оронд тохирох үндсэн хуулийн суурь зарчмыг нөхөж бичнэ үү. /4 оноо/

Нөхөх үгс: /Ардчилсан ёс, эрх чөлөө,шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх,үндэсний эв нэгдлийг хангах/

..... Төрийн байгууллага албан тушаалтанд гомдол гаргах, мэдээлэл хайх, цуглуулах, улс төрийн нам байгуулах, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, Нийгэмд эзлэх байр суурь, албан тушаал, анги, давхарга, шашин шүтлэг, үзэл бодол, нас хүйс, бэлгийн чиг баримжаанаас үл хамаарч, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх

..... Үнэн зөв байх, онол, арга зүй, практикийн бодит үнэнд шүтсэн, зөвийг дээдэлж энэрэн хүндэтгэж, хөхиүлэн дэмждэг, бурууг ялган салгаж жигшин зэвүүцэж чаддаг байх, өөрийн улсад амьдарч аж төрж байгаа үндэстэн, ястан, овог, аймгийн эв эеийг хангах,

35. Дараах хүснэгтэд байгаа тоон мэдээллийг ашиглан асуултад хариулаарай. /4 оноо/

№	Төрөл	2015 он		2016 он	
		Үнэ (P)	Үйлдвэрлэлийн хэмжээ, мян ширхэг (Q)	Үнэ (P)	Үйлдвэрлэлийн хэмжээ, мян ширхэг (Q)
1	Талх	950	700.0	1100	800.0
2	Ургамлын тос	2000	300.0	2300	350.0

Даалгаврыг гүйцэтгэхдээ дараах томъёог ашиглаарай.

$$ДНБ = \sum P_i Q_i = P_1 Q_1 + P_2 Q_2 \quad ДНБ\text{-ий өсөлт} = \frac{ДНБ_{2016}}{ДНБ_{2015}} \times 100\%$$

Асуулт: Тухайн улсын эдийн засгийн өсөлтийг тухайн онуудад хэдий хэмжээтэй байгааг тооцоолоорой.

36. Дээрх хүснэгтэд байгаа тоон мэдээллийг ашиглан асуултад хариулаарай. /4 оноо/

Тухайн улсын эдийн засгийн өсөлтийн үнэ болон бүтээгдэхүүний биет хэмжээ хэдэн хувиар өссөн бэ?


37. МУ-ын үндсэн хуульд зааснаар иргэний журамт үүргийг ялган бичээрэй. /4 оноо/

Монгол улсын иргэний үүрэг	Журамт үүрэг:
1. Хуулийг дээдлэн хүндэтгэх, сахин биелүүлэх	1.
2. Хөдөлмөрлөх	2.
3. Байгаль орчноо хамгаалах	3.
4. Албан татвар төлөх	4.
5. Эрүүл мэндээ хамгаалах	
6. Эх орноо хамгаалах, цэргийн алба хаах	
7. Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх	
8. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх	

38. Төрийн байгууллага ямар эрх зүйн актын төрлийг нөхөж бичээрэй. /4 оноо/

№	Төрийн байгууллага	Эрх зүйн актын төрөл
1	МУ-ын Үндсэн хуулийн цэц	
2	МУ-ын Их Хурал	
3	Монгол Улсын Ерөнхий сайд	
4	МУ-ын засаг дарга	

39. Дараах мэдээлэлд тулгуурлан улс ба улс бус оролцогчийн ижил ба ялгааг венн диаграммаар илэрхийлээрэй. /4 оноо/





40. Монгол улс яагаад сонгодог бага улсын ангилалд хамаардаг вэ?

.....
.....
.....
.....